



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРЧИС ОЙЛ ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/67/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261740 Цахим хаяг: Lkhagvasurenm@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн
Захирал Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: ikhermurun.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. 4. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
5.1 Шилэн дансны мэдээлэл	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
8. Аудитын илрүүлэлт	12
8.1 Залруулсан алдаа	12
8.2 Албан шаардлага	13
8.3 Зөвлөмж	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОХУ	Оросын Холбооны Улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/590
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчис ойл ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрчис ойл ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Байгууллага нь нийт орлогыг 1,619.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,220.9 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 398.3 сая төгрөгөөр тогтоож төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 99.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 393.5 сая төгрөгийн зардал гарган 294.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний 1 худалдан авах ажиллагаанд 30.0 сая төгрөг төлөвлөснөөс 19.3 сая төгрөг зарцуулсан байна.

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний үнэ, валютын ханш, шатахууны импортын үнийн өсөлтөөс шалтгаалан санхүүгийн үүсмэл хэрэглүүр ашиглан шатахууны үнэ тогтворжуулах гэрээ хийгдээгүй тул 2021 оны орлогын төлөвлөгөө тасалдаж, алдагдалтай ажилласан, цаашид ч тодорхойгүй нөхцөл байдал үргэлжилж байгааг аудитын гол асуудлаар дурдаж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн тайланд 4 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	191,000,6 86.78	147,741,2 17.20
1.1.2	Дансны авлага	784,529,5 21.43	17,990,7 56.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	3,963,9 24.30
1.1.4	Бусад авлага	916,4 00.00	4,946,0 69.00
1.1.6	Бараа материал	1,980,6 01.35	4,251,2 68.68
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,566,1 29.00	0.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	983,993,3 38.56	178,893,2 35.18
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	47,535,4 49.71	39,191,3 58.00
1.2.2	Биет бус хөрөнгө	1,782,0 00.00	1,386,0 00.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	49,317,4 49.71	40,577,3 58.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,033,310,7 88.27	219,470,5 93.18
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	471,083,7 61.02	0.00
2.1.1.3	Татварын өр	97,105,6 52.49	39,9 01.40
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,147,0 00.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,690,3 35.00	7,690,3 35.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	573,026,7 48.51	7,730,2 36.40
2.2	Өр төлбөрийн нийт дүн	573,026,7 48.51	7,730,2 36.40
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
	Өмч		
2.3.1	Өмч: а) төрийн	1,000,0 00.00	1,000,0 00.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	459,284,0 39.76	210,740,3 56.78
2.3.11	Эздийн өмчийн дүн	460,284,0 39.76	211,740,3 56.78
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,033,310,7 88.27	219,470,5 93.18

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	752,125,665.91	
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	752,125,665.91	
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	669,482.58	99,033,936.65
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	242,799,896.94	393,506,742.60
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	321,175.27	(25.37)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	510,316,426.82	(294,472,831.32)
19	Орлогын татварын зардал	51,032,387.06	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	459,284,039.76	(294,472,831.32)

21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдлагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	459,284,039.76	(294,472,831.32)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	459,284,039.76	(294,472,831.32)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 4-р сарын 22-ны үлдэгдэл	1,000,000.00		1,000,000.00
Тайлангийн үеийн цэвэр ашиг		459,284,039.76	459,284,039.76
Өмчид гарсан өөрчлөлт	1,000,000.00		1,000,000.00
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	459,284,039.76	460,284,039.76
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		45,929,148.35	45,929,148.35
Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	459,284,039.76	460,284,039.76
Тайлангийн үеийн цэвэр ашиг		(294,472,831.33)	(294,472,831.33)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	210,740,356.78	211,740,356.78

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	8,298,762,612.94	853,075,992.10
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	567,443,007.50	252,038,843.75
1.1.4	Буцаан авсан албан татвар		45,929,148.35
1.1.6	Бусад мөнгөн орлого	7,731,319,605.44	555,108,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	8,108,764,797.93	896,335,436.31
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	144,164,838.00	208,801,621.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	39,811,919.00	66,458,702.60
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	125,351,170.08	165,776,867.18
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	6,720,662.40	81,444,206.46
1.2.9	Бусад мөнгөн зарлага	7,792,716,208.45	373,854,039.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	189,997,815.01	(43,259,444.21)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	1,000,000.00	
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	1,000,000.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,000,000.00	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	3,527.88	87.22
3.1.4	Бусад орлого	3,527.88	87.22
3.2	Мөнгөн зарлагын дүн	656.11	112.59
3.2.5	Бусад зарлага	656.11	112.59

3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,871.77	(25.37)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	191,000,686.78	(43,259,469.58)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	191,000,686.78
6	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	191,000,686.78	147,741,217.20

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Нийт орлого	мян.төгрөг	753,116.3	1,619,318.2	99,033.9	1,520,284.2	6.1
1	Үүнээс:Борлуул алтын орлого	мян.төгрөг	752,125.7	1,619,318.2	99,033.9	1,520,284.2	6.1
2	Нийт зардал	мян.төгрөг	242,799.9	1,220,967.3	393,506.7	827,460.6	32.2
2.1	Үүнээс:Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төгрөг	242,799.9	1,220,967.3	393,506.7	827,460.6	32.2
3	Татварын өмнөх ашиг	мян.төгрөг	510,316.4	398,350.9	(294,472.8)	692,823.7	
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төгрөг	459,284.0	358,515.8	(294,472.8)	652,988.6	
5	Төсвийн төлбөрт	мян.төгрөг	125,223.6	433,186.0	195,228.5	237,957.4	45.1
	Үүнээс:НДШ 24-26%	мян.төгрөг	41,958.9	169,073.3	66,458.7	102,614.6	39.3
	ХХОАТ 10%	мян.төгрөг	15,354.2	62,345.8	30,932.6	31,413.2	49.6
	ААНБОАТ 10%	мян.төгрөг	520.8	39,835.1	50,511.6	(10,676.5)	126.8
	НӨАТ 10%	мян.төгрөг	67,389.7	161,931.8	47,325.6	114,606.2	29.2
6	Нийт ажиллагсдын тоо	хүн	10	21	10	11	47.6
7	Нийт цалингийн сан	мян.төгрөг	179,190.9	704,472.0	257,889.2	446,582.8	36.6
8	Нэг ажилтны дундаж цалин	мян.төгрөг	2,144.4	2,003.0	2,058.9	(55.9)	102.8
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	мян.төгрөг	0.3	0.8	4.0	(3.2)	527.0
10	Хөрөнгө оруулалт	мян.төгрөг	55,964.8	151,150.0	1,592.4	149,557.6	1.1
11	Нийт авлага	мян.төгрөг	791,012.1	-	26,882.7	(26,882.7)	
12	Нийт өглөг	мян.төгрөг	573,026.7	-	7,730.2	(7,730.2)	

3.4. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрчис ойл ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад мөнгөн кассын үйл ажиллагаа, цалингийн зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа, ахлах аудитор Д.Оюундаваа нар гүйцэтгэж, хяналтыг захирал Б.Мядагмаа хэрэгжүүлсэн.

Эрчис ойл ХХК 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 01/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн. Учир нь байгууллага дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар заавар, журам баталж, мөрдөөгүй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрчис ойл ХХК 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 1,033.3 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 20.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрчис ойл ХХК-ийн зорилго нь шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн үйл ажиллагаа эрхлэх, санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан газрын тосны /АИ-92/ бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийг тогтворжуулахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг худалдааны зуучлал, хатуу, шингэн, хийн түлш, түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх, бүх төрлийн шатахууны бөөний болон импортын худалдаа эрхлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Өмчийг үүсгэн байгуулагч “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК 100 хувь эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Засгийн газрын 2020 оны “Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 14 дүгээр тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/81 дүгээр тушаалаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн охин компани болох “Эрчис ойл” ХХК-ийг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ...6/ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах талаар тухайн хуулийн этгээдээс гаргасан саналыг хэлэлцэж шийдвэрлэх;...” гэсэн заалттай нийцэж байна.

Тус компани нь санхүүгийн үүсмэл хэрэглүүр ашиглан шатахууны жижиглэнгийн үнэ тогтворжуулах үйл ажиллагааг амжилттай эхлүүлсэн боловч 2021 онд гадаад зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний үнийн огцом өсөлтөөс шалтгаалж дотоодын зах зээлд борлуулагдаж буй шатахууны үнэ өссөн. Ингэснээр шатахууны үнийг тогтвортой нэг түвшинд барих боломжгүй болж, улмаар “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтарсан зөвлөлийн”-өөс АИ-92 шатахууны үнийг зах зээлийн горимд шилжүүлэн, үнийг аажмаар чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 заалтад “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний 30-аас дээш хувийг дангаараа нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харьяалал, хяналтад байдаг нэгжээрээ дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно.” гэж заасан нь Эрчис Ойл ХХК-ийг олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийн үйл ажиллагааг гадаадын нийлүүлэгч, хөрөнгө оруулагч талтай, үүний дотор хамтын ажиллагааны хэлэлцээр хийж буй ОХУ-ын Роснефть компанитай хамтран хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байгаа тул хуулийн энэ заалтад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр өргөн барьсан байна.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн ТУЗ нь Эрчис ойл ХХК-ийн ТУЗ-ийн үүргийг гүйцэтгэж байна.

Компанийн гүйцэтгэх захирлыг Эрчис ойл ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5.7 заалтыг үндэслэн “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 20 дугаар тогтоолоор томилсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль /нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ/;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрчис ойл ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	191,000.7	147,741.2	(43,259.5)
Авлага	785,445.9	26,900.7	(758,545.2)
Урьдчилгаа	5,566.1	0.0	(5,566.1)
Бараа материал	1,980.6	4,251.3	2,270.7
Үндсэн хөрөнгө	47,535.4	39,191.4	(8,344.1)
Биет бус хөрөнгө	1,782.0	1,386.0	(396.0)
Нийт хөрөнгийн дүн	1,033,310.8	219,470.6	(813,840.2)
Өр төлбөрийн дүн	573,026.7	7,730.2	(565,296.5)
Богино хугацаат өглөг	573,026.7	7,730.2	(565,296.5)
Эздийн өмч	460,284.0	211,740.4	(248,543.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,033,310.8	219,470.6	(813,840.2)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 147.7 сая төгрөгийн 0.5 сая төгрөгийг касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл, 147.2 сая төгрөгийг банкин дахь харилцах дансны үлдэгдэл эзэлж байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх онтой харьцуулахад 43.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны орлогын төлөвлөгөөний тасалдалтай холбоотой байна.

Авлагын үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 758.5 сая төгрөгөөр буурч, 26.9 сая төгрөг болсон ба үлдэгдэл буурахад шатахууны тогтворжуулсан үнийн зөрүүтэй холбоотой авлага бүрэн барагдсан нь нөлөөлжээ. Жилийн эцсийн авлагын үлдэгдлийн 4.0 сая төгрөгийг НӨАТ-ын авлага, 18.0 сая төгрөгийг дансны авлага, 4.0 сая төгрөгийг ажиллагсадтай холбоотой авлага, 0.9 сая төгрөгийг компани хоорондын авлага эзэлж байна. Авлагын үлдэгдэлд хугацаа хэтэрсэн болон найдваргүй авлага байхгүй, хугацаандаа төлөгдөх авлагууд байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй байсан 5.6 сая төгрөгийг тайлант үеийн түрээсийн зардалд тооцож хаасан байна.

Тайлант онд 16.5 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж, 14.2 сая төгрөгийг зарцуулснаар бараа материалын дансны үлдэгдэл 4.3 сая төгрөг болж 2.3 сая төгрөгөөр өсчээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8.3 сая төгрөгөөр буурсан нь Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 1.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авсан, тайлант жилд 9.9 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 7.7 сая төгрөг болж, 565.3 сая төгрөгөөр буурчээ. Энэ нь шатахууны тогтворжуулсан үнийн зөрүүтэй холбоотой өглөг бүрэн барагдсантай холбоотой байна. Өр төлбөрийн үлдэгдэл нь байгууллагад өгөх өглөгийн 7.7 сая төгрөг байна.

Санхүүгийн тайланд 393.5 сая төгрөгийн зардлыг ерөнхий ба удирдлагын зардлаар тайлагнасан байна. Нийт зардлын 74.2 хувь буюу 291.9 сая төгрөгийг цалин, шимтгэлийн зардал, 13.1 хувь буюу 51.4 сая төгрөгийг байрны түрээсийн зардал эзэлж байгаа нь голлох дүнг эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулахад нийт зардал 150.7 сая төгрөгөөр нэмэгдсэний дотор цалин, шимтгэлийн зардал 90.3 сая төгрөгөөр, байрны түрээсийн зардал 35.5 сая төгрөгөөр өсч, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, сургалт, хурал зөвлөгөөний зардал 5.2 сая төгрөгөөр буурчээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу гүйцэтгэх захирал байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Эрчис ойл ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,619.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,220.9 сая төгрөгөөр, 398.4 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоож, үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 151.2 сая төгрөгийг төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 99.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 393.5 сая төгрөгийн зардал гарган, 294.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 99.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,520.3 сая төгрөг буюу 93.9 хувиар тасарсан нь дэлхийн зах зээл дээр Brent төрлийн газрын тосны үнэ огцом өсч, АИ-92 төрлийн шатахууны үнийг тогтворжуулах гэрээ хийгдээгүй нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэлийг 393.5 сая төгрөгөөр тайлагнасан нь төлөвлөснөөс 827.4 сая төгрөг буюу 67.8 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь компанийн орлогын тасалдалтай холбоотой санхүүгийн хүндрэл үүсэх нөхцөл байдал бий болсон тул зардлыг хэмнэж ажиллах талаар ТУЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу өмнөх оноос орон тоог нэмэгдүүлээгүй, цалин, шимтгэлийн зардлыг төлөвлөснөөс 500.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсан болон бусад зардлыг хэмнэж ажилласантай холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өөрийн эх үүсвэрээс 1.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авах зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 398.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн боловч орлогын төлөвлөгөө 93.9 хувь буюу 1,520.3 сая төгрөгөөр тасалдсанаас 294.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрчис ойл ХХК нь тайлант онд нийт 538.9 сая төгрөгийн 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 31.7 сая төгрөгийн ажил гүйлгээний 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, нийт 40 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт болон “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай” хуульд төрийн өмчийн бодлогын талаар заасан заалтыг шалгалаа.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад компанийн ТУЗ-өөс өгсөн чиглэлийн хүрээнд Гүйцэтгэх захирлын 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн “Зардлын төсөвт хэмнэлт хийх тухай” А/06 дугаар тушаал гарч, ажиллагсдын цалин хөлсийг 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд 70 хувиар тооцоолон олгосон, компанийн албан ажлын хэрэгцээнд автомашин худалдаж авахаар гүйцэтгэгчийг шалгаруулсан тендерийг цуцалж, урьдчилгаа төлбөрийг буцааж авсан, түүнчлэн 21 орон тоотой ажиллахаар батлагдсан боловч орон тоог нэмэгдүүлээгүй ажилласан зэрэг арга хэмжээг авч ажилласан байна. Гэвч зочин төлөөлөгчийн зардалд 2.3 сая төгрөг, байр талбай нэмж түрээслэхэд 19.3 сая төгрөг, ажиллагсдад үүрэн телефоны дугаарыг байгууллагын нэр дээр олгож, ярианы төлбөр төлөхөд 3.1 сая төгрөг, нийт 24.7 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Засгийн газрын 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

“Монгол Улсын 2021 оны төсвийн тухай” хуулиар төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг бууруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх талаар заасан заалтын хэрэгжилтийг шалгахад Эрчис ойл ХХК-ийн 2021 оны зорилтот түвшин хангагдаагүй орлогын төлөвлөгөө 93.9 хувиар тасалдаж, 294.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, төрийн өмчийн талаарх зорилтын хэрэгжилтийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 27.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 14.8 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 13.1 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 99.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувийн биелэлттэй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөг/						
	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-			1	-	0
Зөвлөмж	1	99,252.6	1	99,252.6			100.0
Нийт дүн	2	99,252.6	1	99,252.6	1		50.0

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлагын биелэлт хангалтгүй, зөрчлийг давтан гаргасан асуудалд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 59.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 45.9 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 13.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, мөнгөн кассын үйл ажиллагаа, цалингийн зардалтай холбоотой 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлагналтай холбоотой залруулагдаагүй 13.1 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 20.7 сая төгрөгийн түвшин 7.6 сая төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 45.9 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.1 заалтыг үндэслэн өмнөх онд ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлж, Татварын албанаас буцаан олгосон 45.9 сая төгрөгийг тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй тул өмнөх үеийн үр дүнд залруулсан.

8.2 Албан шаардлага

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-д хамаарах 13.1 сая төгрөгийн зардлыг ТУЗ-ийн 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолыг үндэслэн шилжүүлж, авлага үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.1.бие даасан байх;”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 “Хараат болон охин компани нь толгой компанийнхаа өрийг хариуцахгүй бөгөөд хууль болон тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол толгой компани нь хараат болон охин компанийнхаа өрийг хариуцахгүй.” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрчис ойл ХХК нь мөнгөн кассын үйл ажиллагааны талаар тогтоосон дүрэм, журам байхгүй, жижиг мөнгөн сангийн хязгаар тогтоогоогүй, нярвын ажлыг хариуцсан ажилтан байхгүй, нягтлан бодогч няравын ажлыг давхар хариуцан ажиллаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 заалтад “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 заалтад “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.” заалтуудыг тус тус зөрчиж, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жижиг мөнгөн сангийн хязгаар тогтоож, үйл ажиллагааг нь журамлах, мөнгөн касс хариуцсан ажилтантай болж, нягтлан бодогч хяналт тавьж ажиллах.

2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 заалтад “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ...”, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 2 дугаар заалтад “Ажил олгогч нь бүх ажилтныг ажлын жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлэх бололцоогоор хангаж, эдлүүлнэ.”, 4 дүгээр заалтад “Ажилтны ээлжийн амралтыг ажлын жилээр нь тооцон олгоно. Ээлжийн амралт олгох ажлын жил нь ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагад анх ажилд орсон өдрөөс эхлэн тооцогдоно.”, Эрчис ойл ХХК-ийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.15 заалтад “...Тухайн жилийн ээлжийн амралтыг биеэр эдэлсэн байх асуудлыг албадын дарга нар бүрэн зохицуулна.” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй, ээлжийн амралтаа биеэр эдлээгүй 5 ажилтанд мөнгөн урамшуулал олгож, цалингийн зардлыг нэмэгдүүлсэн нь “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг жилийн эхэнд баталж, жил бүр ээлжийн амралтаа биеэр эдлэх нөхцөл бололцоогоор хангах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/										
					Нийт алдаа, зөрчлийн дүн			Үүнээс							
					Тоо	Дүн	Тоо	Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох	
			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1	Эрчис ойл ХХК	АХГ-2022/67/НА-СТА-ТӨА	Мөнгөн кассын үйл ажиллагааны талаар тогтоосон дүрэм, журам байхгүй, жижиг мөнгөн сангийн хязгаар тогтоогоогүй, нярвын ажлыг хариуцсан ажилтан байхгүй, нягтлан бодогч давхар хариуцаж байна.	Жижиг мөнгөн сангийн хязгаар тогтоож, үйл ажиллагааг нь журамлах, мөнгөн касс хариуцсан ажилтантай болж, нягтлан бодогч хяналт тавьж ажиллах.	1								1	-	
2	Эрчис ойл ХХК	АХГ-2022/67/НА-СТА-ТӨА	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-д хамаарах зардлыг ТУЗ-ийн 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолын дагуу Эрчис ойл ХХК-аас төлж, авлага үүсгэсэн байна.	Бие даасан байх зарчмыг хангаж, толгой компанитай холбоотой авлагыг барагдуулах	1	13,104.9					1	13,104.9			
3	Эрчис ойл ХХК	АХГ-2022/67/НА-СТА-ТӨА	Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 заалт, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан "Ээлжийн амралт олгох заавар"-ын 2 болон 4 дүгээр заалт, Эрчис ойл ХХК-ийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.15 заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, ээлжийн амралтаа биеэр эдлээгүй 5 ажилтанд мөнгөн урамшуулал олгож, цалингийн зардлыг нэмэгдүүлсэн нь байна.	Ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг жилийн эхэнд баталж, жил бүр ээлжийн амралтаа биеэр эдлэх нөхцөл бололцоогоор хангах.	1								1	-	

4	Эрчис ойл ХХК	АХГ- 2022/67/НА- СТА-ТӨА	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.1 заалтыг үндэслэн өмнөх онд ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлж, Татварын албанаас буцаан олголтыг тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	Санхүүгийн тайланд залруулан бүртгэх	1	45,929.1	1	45,929.1										
ДҮН					4	59,034.0	1	45,929.1				1	13,104.9				2	-
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																		
1	Эрчис ойл ХХК	АХГ- 2022/67/НА- СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд 148 мэдээлэл оруулахаас 146 мэдээлэл оруулсан боловч 40 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 31,680.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг мэдээлээгүй.	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт хангалтгүй, зөрчлийг давтан гаргасан асуудалд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх	1	31,680.0											1	31,680.0
2	Эрчис ойл ХХК	АХГ- 2022/67/НА- СТА-ТӨА	Зочин төлөөлөгчийн зардалд 2,290.0 мянган төгрөг, байр талбай нэмж түрээслэхэд 19,320.0 мянган төгрөг, ажиллагсад үүрэн телефоны дугаарыг байгууллагын нэр дээр олгож, ярианы төлбөр төлөхөд 3,125.6 мянган төгрөг, нийт 24,735.6 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, зайлшгүй шаарлагатайгаас бусад зардал гаргахгүй байхад анхаарах	1	24,735.6						1	24,735.6					
3	Эрчис ойл ХХК	АХГ- 2022/67/НА- СТА-ТӨА	2021 оны зорилтот түвшин хангагдаагүй орлогын төлөвлөгөө 6.1 хувийн биелэлттэй, 294,472.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	Компанийн зорилтот түвшинг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах	1							1						
ДҮН					3	56,415.6						2	24,735.6	1	31,680.0			
НИЙТ ДҮН					7	115,449.6	1	45,929.1				3	37,840.5	1	31,680.0		2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 487/А0150053

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчис ойл ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн 2021 оны зорилтот түвшин хангагдаагүй, орлогын төлөвлөгөө 93.9 хувиар тасалдаж, 294,472,831.32 төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ийн 15.1.3 “Төрийн өмчийн байгууллагын менежментийг сайжруулах, ашигтай ажиллуулах замаар орлогыг төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн зорилтот түвшинг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн захирал З.Ширзана, нягтлан бодогч Д.Мядагдам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Б.МЯДАГМАА

9006109
9019120396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 488 /А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/67/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчис ойл ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант жилд зочин төлөөлөгчийн зардалд 2,289,964.34 төгрөг, ажлын байрны талбай нэмж түрээслэхэд 19,320,000.00 төгрөг, компанийн ажиллагсдад үүрэн телефоны дугаарыг байгууллагын нэр дээр олгож 3,125,630.00 төгрөг, нийт 24,735,594.34 төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал гаргахгүй байхад анхаарах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн захирал З.Ширзана, нягтлан бодогч Д.Мядагдамад нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Б.МЯДАГМАА

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-364230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-152.Docx

0001081298



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 489/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/67/НА-СТБ-ТӨА

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчис ойл ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим мэдээллийн санд байршуулбал зохих 148 мэдээллээс 40 мэдээллийг хугацаа хоцроож, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31,680,000.00 төгрөгийн ажил, гүйлгээний 2 мэдээллийг байршуулаагүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчис ойл ХХК-ийн захирал З.Ширзанад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХЭРМӨРӨН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Б.МЯДАГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 490/А0150053
АХГ-2022/67/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчис ойл ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-д хамаарах 13,104,940.00 төгрөгийн зардлыг ТУЗ-ийн 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолоор шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.1.бие даасан байх;" 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 "Хараат болон охин компани нь толгой компанийнхаа өрийг хариуцахгүй бөгөөд хууль болон тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол толгой компани нь хараат болон охин компанийнхаа өрийг хариуцахгүй." заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бие даасан байх зарчмыг хангаж, толгой компанитай холбоотой авлагыг барагдуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн захирал З.Ширзана, нягтлан бодогч Д.Мядагдадам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Б.МЯДАГМАА

